

Сургуулиуд ба сургуулийн гуанзны үйл ажиллаганы өөрчлөлт **(эх сурвалж: <https://www.msmt.cz/>)**

2020 оны 11-р сарын 25-ны Лхагва гарагаас эхлэн сургуульд хооллоход:

Сургуулийн хоолны газрууд ажиллаж байна. Үйл ажиллагаа нь нийтэд үйлчлэхгүй хоолны үйлчилгээний үйл ажиллагааны дүрмээр зохицуулагдах болно.

Хооллох үйл ажиллагаанд дараахь зүйлсийг зайлшгүй дагаж мөрдөх шаардлагатай:

- ширээнүүд хоорондоо 1,5 метр зайтай байх,
- нэг ширээн дээр суух хүмүүсийн тоо хамгийн ихдээ 4 хүн байна (хэрэв урт ширээ бол олон хүн сууж болно, тэгэхдээ хэсэг бүлэг нь хоорондоо багадаа 2 метр зайтай байхаар),
- сургуулийн гуанзанд суух хүний тооноос хэтэрсэн хүмүүс нэг зэрэг байж болохгүй,
- сургуулийн гуанзанд зөвхөн өдрийн ангийн сурагчид, оюутнууд болон ажлын байран дээр байгаа сургуулийн багш нар л хооллож болох бөгөөд гаднаас хооллодог хүмүүс хоол олгох цонхоор хоолоо авч болно (авч явах),
- хоол авахаар хүлээх ба хооллох үед дараахь зүйлс хэрэгжсэн байхаар зохион байгуулалтын арга хэмжээ авах хэрэгтэй:
 - өөр өөр ангийн/бүлгийн/тасгийн сурагчид/оюутнууд хоорондоо зөрж сүлжихгүй байх
 - өдрийн ангийн сурагчид/оюутнууд авч явах хэлбэрээр хоол авдаг бусад хүмүүстэй зөрж сүлжихгүй байх.

Сурагчид заавал суралцах алсын зайны сургалтын хугацаанд хөнгөлөлттэй үнээр өдрийн хоолондоо хамрагдах эрхтэй.

Сурагчид/оюутнууд ба сургуулийн ажилтнууд хооллохоос бусад тохиолдолд сургуулийн гуанзанд маск зүүх ёстой.

11-р сарын 30-аас сургуулиудын үйл ажиллагаа

2020 оны 11-р сарын 30-ны Даваа гарагаас эхлэн цэцэрлэгүүдийн үйл ажиллагаа:

- Гарын авлагын дагуу үйл ажиллагааны дүрмийг баримталсан нөхцөлд цэцэрлэгүүдийн үйл ажиллагаа (Боловсролын тухай хуулийн § 16-гийн 9-р догол мөрийн заалтын дагуу байгуулагдсан сургууль, ангиуд орно) нь урьдын адил хэвээр байна.
- Хүүхдүүд ба сурган хүмүүжүүлэгч ажилтнууд маск зүүх үүрэггүй. Бусад ажилтнууд ба сургууль дотор яваа хүмүүс сургууль дотор байх бүх хугацаандаа маск зүүх үүрэгтэй.
- Хүүхдийг дагуулж яваа хүн хувцасны өрөөнд (зайлшгүй шаардлагатай хугацаагаар) орж болно. Гуравдагч этгээд (хүүхдүүд ба ажилтнуудаас бусад) сургуулийн байранд нэвтрэх нь ерөнхийдөө зөвхөн хүүхдүүдтэй харьцах харьцааг багасгах горимын арга хэмжээ авах үндэслэлтэй тохиолдолд л боломжтой байна. Жишээлбэл, хүүхдүүдийн хууль ёсны төлөөлөгчид, хяналтын байгууллагууд (жишээлбэл, ČŠI), сургуулийн зөвлөгөө өгөх байгууллагуудын ажилтнууд, бүс нутгийн эрүүл ахуйн станцууд, хангамж нийлүүлж буй хүмүүс эсвэл бусад шаардлагатай үйлчилгээнүүд гуравдагч этгээдийн жишээ байж болно.

2020 оны 11-р сарын 30-ны Даваа гарагаас эхлэн суурь сургуулийн үйл ажиллагаа:

- Дараахь хүмүүс биеэрээ байхыг зөвшөөрнө:
 - суурь сургуулийн бэлтгэл ангид хамрагдсан хүүхдүүд,
 - суурь сургуулийн 1-р шатны сурагчид,
 - суурь сургуулийн 9-р ангийн сурагчид,
 - хичээлийн тойргийн горим гэгч – долоо хоногоор бүтэн ангиар ээлжлэх суурь сургуулийн 6 - 8-р ангийн сурагчид,
 - хуулийн хүмүүжил юмуу хамгааллын хүмүүжлийн гүйцэтгэлийн зорилгоор байгуулагдсан сургуулийн сурагчид,
 - эрүүл мэндийн байгууллагуудад байгуулагдсан сургуулийн сурагчид.
- Эдгээр сурагчид өдрийн цагаар хичээллэх ёстой.
- Боловсролын хуулийн § 16-гийн 9-р догол мөрийн заалтын дагуу тойргоор хичээллэх нь суурь сургуулийн 2-р шатны сурагчид ба ангиудад хамаарахгүй (тэдний хувьд сургалтанд биеэрээ оролцох нь үргэлжилсээр байна).
- Ээлжээр (ээлжлэн) сургах зорилго нь шилжилтийн үед сургуульд байх сурагчдын тоог багасгах зорилгоор зохион байгуулах явдал юм:
 - Сургуулийн захирал ангиудыг (ангиуд нь дотроо хуваагдахгүй) хоёр бүлэгт хувааж, сондгой долоо хоногт аль бүлэг, тэгш долоо хоногт аль бүлэг нь хичээлд биеэрээ ирэхийг тодорхойлно. Хоёр бүлгийн ангийн тоо ихдээ 1 ангиар ялгаатай байж болно.
 - Тухайн долоо хоногт өдрийн ангийн хичээлгүй ангиудыг заавал зайнаас сургана. 9-р ангийн бүх ангиуд заавал өдрийн цагаар хичээллэнэ.
- Өдрийн ангийн хичээл нь нэгэн төрлийн бүлэгт явагдана (нэг ангийн хамт олон нь нэгдэхгүй ба сөөлжиж зөрөхгүй). Өөр өөр ангийн сурагчдын хооронд ямар ч холбоо байхгүй байлгах үүднээс сурагчдын ирэх, гарах явдлыг зохион байгуулахыг зөвлөж байна.
- Тухайн цагт зайн сургалтаар боловсрол эзэмшиж буй сурагчдын хувьд ч гэсэн сурагчийн хууль ёсны төлөөлөгч оролцож болох сургуульд биеэр өдөр бүр зөвлөгөө авах боломжтой (зөвхөн нэг сурагч, нэг сурган хүмүүжүүлэх ажилтан).
- Сурагчид болон сургуулийн ажилтнууд сургуульд байх бүхий л хугацаандаа (өдөр өнжүүлэх, сургуулийн клубт мөн адил) масктай байх ёстой. Хичээлийн үеэр сурагчид багшийн амыг зайлшгүй харах шаардлагатай байвал хамар болон амны хамгаалалтыг бүх хүмүүсээс дор хаяж 2 метр зай барьсан тохиолдолд хамгаалалтын хаалтаар орлуулж болно.
- Сургуулийн байранд гуравдагч этгээд (сурагч, ажилчдаас бусад) орох нь ерөнхийдөө зөвхөн сурагчидтай харьцах харьцааг багасгах горимын арга хэмжээ авсны дараа үндэслэлтэй тохиолдолд л боломжтой байна. Жишээлбэл, насанд хүрээгүй хүүхдүүд, сурагчдын хууль ёсны төлөөлөгчид, шалгалтын комиссын гишүүд, хяналтын байгууллагууд (жишээ нь ЦСИ), сургуулийн зөвлөгөө өгөх байгууллагууд, бүс нутгийн эрүүл ахуйн станцуудын ажилтнууд, хангамжийн хэрэгслээр хангаж байгаа хүмүүс эсвэл бусад шаардлагатай үйлчилгээг гуравдагч этгээдийн жишээ болгож болно.
- Боловсрол олгох үеэр дуулах, спортоор хичээллэхийг хориглоно (усанд сэлэх мөн адил).
- Нэг ангийн сурагчид нэг дор байх байдлыг хадгалж өдөр өнжүүлэх бүлэг, сургуулийн клубыг ажиллуулах боломжтой. Хэрэв боловсон хүчний зүгээс боломжгүй бол өдөр өнжүүлэх бүлэгт (сургуулийн клубт биш) нэг жилийн ангийн сурагчдыг хамруулах боломжтой.
- Нэг бүлгийн нэгдмэл байдлыг хадгалсан нөхцөлд сургуулийн гадна талбайд, тэр ч байтугай гадуур, боловсролын үйл ажиллагаа явуулж болно.
- Засгийн газрын 1109-р тогтоолын дагуу сонгогдсон сургууль, сургуулийн барилга байгууламжийн үйл ажиллагаа (сонгосон мэргэжлээр эцэг эхийн хүүхдүүдэд анхаарал тавих) зогсож байна.

2020 оны 11-р сарын 30-ны Даваа гарагаас эхлэн тусгай сургуулиудын үйл

ажиллагаа:

- Улмаар дараахь хүмүүс биеэрээ байхыг зөвшөөрнө:
 - Боловсролын тухай хуулийн §16-гийн 9-р догол мөрийн дагуу байгуулагдсан суурь сургууль ба ангийн сурагчид,
 - тусгай суурь сургуулийн бэлтгэл шатны хүүхдүүд,
 - нэг жилийн Дадлага сургууль ба хоёр жилийн Дадлага сургуульд мэргэжилд суралцаж буй сурагчид.
- Эдгээр сурагчид өдрийн сургалтыг үргэлжлүүлэн явуулах үүрэгтэй.
- Өдрийн ангийн хичээл нь нэгэн төрлийн бүлэгт явагдана (нэг ангийн хамт олон нь нэгдэхгүй ба сөөлжиж зөрөхгүй). Өөр өөр ангийн сурагчдын хооронд ямар ч холбоо байхгүй байлгах үүднээс сурагчдын ирэх, гарах явдлыг зохион байгуулахыг зөвлөж байна. Хүүхдүүд, сурагчид, багш нар маск өмсөх шаардлагагүй (өдөр өнжүүлэх бүлэг, сургуулийн клубт ч мөн адил).
- Сургуулийн байранд гуравдагч этгээд (сурагч, ажилчдаас бусад) орох нь ерөнхийдөө зөвхөн сурагчидтай харьцах харьцааг багасгах горимын арга хэмжээ авсны дараа үндэслэлтэй тохиолдолд л боломжтой байна. Жишээлбэл, насанд хүрээгүй хүүхдүүд, сурагчдын хууль ёсны төлөөлөгчид, шалгалтын комиссын гишүүд, хяналтын байгууллагууд (жишээ нь ЦСИ), сургуулийн зөвлөгөө өгөх байгууллагууд, бүс нутгийн эрүүл ахуйн станцуудын ажилтнууд, хангамжийн хэрэгслээр хангаж байгаа хүмүүс эсвэл бусад шаардлагатай үйлчилгээг гуравдагч этгээдийн жишээ болгож болно.
- Нэг бүлгийн нэгдмэл байдлыг хадгалсан нөхцөлд сургуулийн гадна талбайд, тэр ч байтугай гадуур, боловсролын үйл ажиллагаа явуулж болно.
- Нэг ангийн сурагчид нэг дор байх байдлыг хадгалж өдөр өнжүүлэх бүлэг, сургуулийн клубыг ажиллуулах боломжтой. Хэрэв боловсон хүчний зүгээс боломжгүй бол өдөр өнжүүлэх бүлэгт (сургуулийн клубт биш) нэг жилийн ангийн сурагчдыг хамруулах боломжтой.
- Дээр дурдаагүй (энэ нь нэг жилийн Дадлага сургууль ба хоёр жилийн Дадлага сургуульд мэргэжилд суралцахаас өөр дунд сургууль ба мэргэжлийн дээд сургуулийн хувьд) Боловсролын тухай хуулийн § 16-ийн 9-р заалтын дагуу бусад сургууль, ангиудын үйл ажиллагааг холбогдох төрлийн сургуулийн үйл ажиллагаа, тэдгээрийн тогтмол ангиар удирдаж зохицуулна.